



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Чингэлтэй дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны
хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр Хурал, Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100 01

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 сарын 21-ний
өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
үйл ажиллагааны хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилго: Хүний хөгжилд тулгуурласан, Төр иргэний хамтын ажиллагаанд суурилсан, дүүргийн нийгэм, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангасан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим:

1. Хурлын байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байна.
2. Хэрэгжих үйл ажиллагаа бүр нь шударга эрх тэгш байдлыг хангасан байна.
3. Хөтөлбөр хэрэгжүүлэгч бүр өөрийн нөөц бололцоо, мэдлэг чадвараа бүрэн дайчлан хариуцлагатай ажиллана.
4. Ажил хариуцагч бүр шинийг эрэн хайж, өөрчлөлт шинэчлэлтийг хийж ажиллана.

Хөтөлбөрийн зорилт:

Нэг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлнэ.

1.1. Хурлын байгууллагын бодлого, зорилт, үндсэн чиг үүргийг бодлогын түвшинд хэрэгжүүлж, үйл ажиллагааны үр нөлөөг хэлбэрэлтгүй дээшлүүлэх

1.2. Хурал, Тэргүүлэгчдийг хуралдаа ажиллах нөхцөл бололцоог хангах, Хурлын Төлөөлөгчдийн сонгогдсон тойрогтоо ажиллахад нь санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар Төлөөлөгч иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх

1.3. Хууль тогтоомж, УИХ, Засгийн газар, Төрийн эрх бүхий байгууллага, Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах

1.4. Хурал, Засаг даргын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, хамтран ажиллах замаар нутгийн удирдлагын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах

1.5. Хууль тогтоомж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтын хэрэгжилт, цаг үеийн шаардлагатай бусад асуудлаар хурлын хороодоос эрхэлсэн асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт, мониторинг, судалгаа хийх, санал дүгнэлт, зохистой шийдлийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, нийтийн анхаарал татсан асуудлаар тавьсан асуулгын мөрөөр ажиллах, Хурал, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, баталсан хөтөлбөр, зорилт бүрийнхээ хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцох, зохион байгуулсан ажлаа тайлагнан сурталчилах зэрэг нутгийн өөрөө удирдах байгууллагын байнгын үйл ажиллагаа, хүлээсэн хариуцлага, сонгогчдын итгэл найдварыг биелүүлэхтэй холбоотой манлайлалыг хангахад ахиц өөрчлөлт гаргах

1.6. Дүүргийн хүн амын нийтлэг эрх ашиг, нийгэм эдийн засгийн аливаа асуудлыг бие даан хэлэлцэн шийдвэрлэх, иргэд байгууллага аж ахуйн нэгжээс нийтээр дагаж мөрдөх нийтлэг дүрэм, журмын чиглэлийг тогтоох ажилд Хурлын байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэн түүний биелэлт үр дүнг дээшлүүлэх

1.7. Шаардлагатай асуудлаар дунд хугацааны тусгайлсан дэд хөтөлбөр, баримт бичгүүдийг боловсруулан баталж, мөрдүүлэх зэрэг удирдлага зохицуулалтын арга хэмжээг авах

1.8. УИХ, Нийслэлд сонгогдсон гишүүд, төлөөлөгчдийн иргэд сонгогчидтой хийх уулзалтыг зохион байгуулах, иргэдийн санал хүсэлтийн мөрөөр хамтран ажиллах замаар иргэд сонгогчидтой нь холбох

1.9. Хурлын байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх, харилцах ажлын хүрээ, гүйцэтгэх үүргийг өргөжүүлэх, иргэд сонгогчидтой байнгын харилцаатай байж, иргэд, гүйцэтгэх засаглалыг холбох гүүр болж ажиллах

1.10. Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх

1.11. Хурлын Төлөөлөгчдийг мэдээ мэдээллээр хангах, сургалтын эрэлт хэрэгцээ, ажлын шаардлагыг нь харгалзан зорилтот болон захиалгат сургалтанд хамруулах

1.12. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг сайжруулж, чадавхийг нь бэхжүүлэх мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах замаар нутгийн өөрөө удирдах ёсыг анхан шатны нэгжид төлөвшүүлэхэд бүхий л талын дэмжлэг үзүүлэх

1.10. Нутаг дэвсгэр дэх шашин, сүм хийд, аж ахуйн нэгж, Төрийн бус олон нийтийн байгууллагуудтай ажил төрлийн холбоотой хамтран ажиллаж, тэдний санал санаачлагыг дэмжих

1.13. Хурлын байгууллагын дэргэдэх салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, чиглэл тус бүрээр цогц бодлого, зорилтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, үр дүнд хүрсэн ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэх

1.14. Харилцаат бүхий Улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, стратегийн түншлэлийг тогтоон, оюутан, сурагч солилцох, мэргэжилтэн бэлтгэх, дүүрэг хөгжүүлэх бүтээн байгуулалтын болон нийгмийн бүхий л салбарт хамтран ажиллах санал санаачлагыг дэмжих

1.15. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжтэй, нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлж, ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, харилцан туршлага солилцох, сайн туршлагыг дүүрэг орон нутагтаа хэрэгжүүлэх бодлого боловсруулах

Хоёр. Хурлын байгууллагын бодлого шийдвэр, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангана.

2.1. Хурлын байгууллагаас дэвшүүлсэн бодлого, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг иргэдээр хэлэлцүүлж, захиргааны актын оновчтой байдлыг хангах

2.2. Дүүрэг, орон нутгаа хөгжүүлэх санал санаачлага гаргагчдыг дэмжин, хамтран ажиллаж, иргэдийн энэ талын мэдлэгийг дээшлүүлэх дэс дараатай арга хэмжээ авах

2.3. Иргэдийн оролцоотой, хариуцлагатай төсвийн орчинг бүрдүүлж төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4. Төр-иргэний нийгмийн түншлэлийн чанар, үр нөлөөг дээшлүүлж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлэх

2.5. Хурлын байгууллагаас баталсан шийдвэр, бодлого, зорилтоо иргэдэд шуурхай хүргэх, сурталчилах, байнгын тогтолцоог бүрдүүлэх

2.6. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам, олон нийт, иргэдийн хэлэлцүүлэгээр эрэмбэлж, өргөн мэдүүлэх журмыг хэвшүүлэх.

2.7. Иргэний танхимын боловсон хүчин, санхүү, техник хангамжийг бэхжүүлэх замаар иргэдийн хөгжих нөхцөл бололцоог дээшлүүлэх

2.8. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, гарсан шийдвэрийн хариуг шуурхай хүргүүлэх замаар эргэх холбоотой ажиллах, чирэгдэлгүй Төрийн үйлчилгээг үзүүлэх

2.9. Нийгмийн зорилтот бүлэгрүү чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх, энэ чиглэлээр олон нийт, Төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.

2.10. Төрийн үйлчилгээний хүртээмж, нийгмийн болон зорилтод бүлгүүдэд чиглэсэн судалгаанд үндэслэн бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэх, иргэнд түгээмэл үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажлыг иргэдийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгаагаар үнэлэх зэрэг үйлчилгээний арга хэлбэрийг нь боловсронгуй болгох, хүртээмж чанарыг сайжруулах санал санаачлагыг дэмжих.

Гурав. Хурлын байгууллагын үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байдлын зарчим, шаардлагад нийцүүлнэ.

3.1. Хурлын Ажлын албаны бүтэц, нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, чиг, үүрэгт тавигдах шалгуур, шаардлага, хариуцлагыг бодлого, зорилтод уялдуулан шинэчлэх.

3.2. Албан хаагчдын ёс зүйд хяналт тавих, шаардлагыг өндөржүүлэх, албан хаагчдын харилцааны соёлыг сайжруулах, ажлын хариуцлага, санаачлагыг дээшлүүлэн Төрийн жинхэнэ албан хаагчдийг төлөвшүүлэх, үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог нэвтрүүлж, гүйцэтгэлийг үр дүнд суурилсан аргаар үнэлэх хэлбэрийг хэвшүүлэх замаар төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх

3.3. Албан хаагчдын ажлын шаардлага, эрэлт хэрэгцээг үндэслэн зорилтод болон захиалгат, мэргэшүүлэх, давтан сургах сургалтуудад хамруулах замаар мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх

3.4. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд албан хаагчдын нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэх, шагнаж урамшуулах асуудлыг шат дараатай зохион байгуулах

3.5. Төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, хариуцлагыг дээшлүүлэх

3.6. Хурлын байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг олон нийтэд шуурхай түгээх замаар иргэдийг мэдээ, мэдээллээр хангах

3.7. Хурал, Тэргүүлэгчид, Хурлын хороодын хуралдаан, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй ил тод болгох, үйл явцыг шуурхай хүртээмжтэй сурталчилж, мэдээ, мэдээллийн үнэн бодит, нэгдмэл байдлыг хангах

Дөрөв. Нутаг дэвсгэртээ нийгмийн дэг журмыг хангах, иргэдийн амар тайван ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

4.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, иргэдийн аюулгүй орчинд тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

4.2. Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хороодын салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх

4.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоо, төрийн болон Төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагуудыг татан оролцуулах, тэдний идэвх санаачлагад суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц бодлого хэрэгжүүлэх

4.4. Нийгмийн дэг журмыг сахиулах, орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг үйлчилгээний хүрээнд хангуулах, холбогдох хууль, журмыг мөрдүүлэх талаар хууль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах.

4.5. Гэмт хэрэгтэй тэмцэх ажилд олон улсын туршлага, шинэ арга барилыг нэвтрүүлэх

4.6. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, хэрэг, зөрчлийг бууруулах талаар мэдээлэл сурталчилгаа хийх зэрэг олон талт арга хэмжээг холбогдох талуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх.

4.7. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.

4.8. Хурлын байгууллагын үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх арга зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс 2015 онд хэлэлцэх асуудлын сэдэвчилсэн төлөвлөгөөг нэгдүгээр, Хурлын хороодоос 2015 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёдугаар, Хурлын Ажлын албанаас 2015 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг Хурал, Тэргүүлэгчдэд улирал тутамд тайлагнаж ажиллахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100 04

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 сарын 21-ний
өдрийн 02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2015 ОНЫ ХУРАЛДАНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах хэлтэс, албад	Хуралдаанд асуудал оруулах албан тушаалтан
НЭГ. ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР				
1	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай	1 дүгээр сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
2	“Амар тайван Чингэлтэй хөтөлбөр” батлах тухай	1 дүгээр сард	Гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
3	Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас 2015 онд хэлэлцэх асуудал, зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай	1 дүгээр сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
4	Ахмад настанд ээлтэй байгууллага иргэнийг шалгаруулж, шагнах тухай журам шинэчлэн батлах тухай	2 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
5	“Соёлын төлбөрт үйлчилгээний хураамж”-ийн журам батлах тухай	2 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
9	“Халдварт өвчинтэй тэмцэх дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	4 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат

10	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	6 дугаар сард	Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
11	“Бүтээмжтэй ажлын байр хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
12	“Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт	8 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
13	“Дүүргийн 2014-2016 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
14	“Иргэний оролцоог дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
15	“Боловсрол-2016 хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
16	“Ногоон дүүрэг хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
17	“Цахим сургууль, цахим цэцэрлэг хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
18	Дүүргийн 2014-2016 оны “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат

19	“Хоршоо хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
20	“Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
21	“Халамжаас хамгаалалд, хамгааллаас халамжид хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
22	“Хамтдаа хөгжье хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
23	“Хотын иргэн-хотын соёл хөтөлбөр”-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
24	“Ахуй үйлчилгээг дэмжих дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
25	“Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
26	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
27	“Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт	12 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
28	Цаг үеийн асуудлаар	Тухай бүрт	-	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1	Дүүргийн 2014 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлж байгаа ажлын танилцуулга	2 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
2	Нийслэл, дүүргийн төсвөөр 2015 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний бэлтгэл ажлын явцын мэдээлэл	3 дугаар сард	Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
3	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	3 дугаар сард	Ногоон булан, Цонжин болдог дахь ахмадын амралт сувилалын газар, БИТ, Нийтлэг үйлчилгээний газар	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
4	Гамшиг ослын цагийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	4 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
5	Хүүхдийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа	5 дугаар сард	Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
6	УБ цахилгаан түгээх сүлжээ ХК-ний Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн үйл ажиллагаа	5 дугаар сард	Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
7	Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай	2 улирал	Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
8	Дүүргийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай	2 улирал	Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
9	Зуслангийн ногоон бүс, товчооны үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай	6 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын	Засаг даргын Тамгын газрын дарга

	/нийтийн тээвэр, хог хаягдал, усан хангамж/			хэлтэс	Ж.Эрдэнэбат
10	Хурлын Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидтойгоо ажилласан байдал, Хурлаас зохион байгуулсан ажилд оролцсон оролцоо, ирц, тайлан	6,12 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
11	Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	6,12 дугаар сар	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
12	Хурал, Тэргүүлэгчдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байдал	6,12 дугаар сар	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
13	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны нийгэм, эдийн засгийн зорилтын хэрэгжилт, үр дүн	6,12 дугаар сар	Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Газрын дарга Ж.Эрдэнэбат	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
14	Өвөлжилтийн бэлтгэл ажил, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Газрын дарга Ж.Эрдэнэбат	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
15	Цахим засаглалыг эрчимжүүлэх арга хэмжээний тухай	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
16	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийж буй ажил, цаашид авах арга хэмжээний тухай	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
17	Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын төсөл	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
18	Дүүргийн 2016 оны төсвийн төсөл	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
19	Дүүргийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2016 оны	12 дугаар сард	Засаг даргын дэргэдэх Өмч, газрын харилцааны алба	Засаг даргын Тамгын газрын дарга	Засаг даргын Тамгын газрын дарга

	төлөвлөгөөний төсөл			Ж.Эрдэнэбат
20	Цаг үеийн асуудлаар	Тухай бүрт	-	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
ГУРАВ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД				
1	"Алдарт эх"-ийн одонгоор шагнуулах эхчүүдийг уламжлах тухай	3 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
2	Цэргийн дүйцүүлэх албаны нэрс батлах тухай	5, 10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
3	"Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн"-ийг шалгаруулж, шагнах тухай	10 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
4	Хурал, Тэргүүлэгчид түүний ажлын албанаас зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Улирал тутамд	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
5	Шилдэг аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулж шагнах тухай	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс	Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Эрдэнэбат
6	Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
7	Хурлын шагналагаар шагнах тухай	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
8	Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
9	Буцалтгүй тусламж олгох тухай	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал
10	Цаг үеийн асуудлаар	Тухай бүрт	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Хурлын ажлын алба Ц.Алтанцацрал

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 сарын 21-ний
өдрийн 02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХОРООДООС
2015 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Хамтран ажиллах хэлтэс, албад
НЭГ. ЭРХ ЗҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО			
1	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Татварын хэлтсийн үйл ажиллагаа, татвар хураалтын байдалтай танилцах	3 дугаар сард	Засаг даргын дэргэдэх Татварын хэлтэс
2	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг архи согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын үйл ажиллагаатай танилцах	4 дүгээр сард	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
3	“Нийтийн байрны үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нийтлэг журам”-ын хэрэгжилт	5 дугаар сард	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
4	“Дүүргийн 2014-2016 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
5	Дүүргийн 2014-2016 оны “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
6	Цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах, дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	11 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс

8	“Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт	12 дугаар сард	Хурлын Ажлын алба
9	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийн явц, байдал /харьяалах асуудлаар/	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газар
10	Хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын Ажлын алба
ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО			
1	Хүүхдийн хууль зүйн хороо, гэр бүл, хүүхэд, хөгжлийн төвийн үйл ажиллагаа, сурагч солилцооны хөтөлбөрийн хэрэгжилт	2 дугаар сард	Хүүхэд, гэр бүл, хөгжлийн төв
2	Ахмад настны нийгмийн хамгаалал, ахмадын хороо, ахмадын амралт сувилалын газрын үйл ажиллагаа	3 дугаар сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
3	“Халдварт өвчинтэй тэмцэх дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	4 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
4	Дүүргийн халамж, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаатай танилцах	4 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Халамж үйлчилгээний хэлтэс
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хөгжүүлэх төвийн үйл ажиллагаа	5 дугаар сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
6	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	6 дугаар сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс
7	Бүтээмжтэй ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилт	6 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
8	ЕБС, цэцэрлэгийн хүүхдүүдийн харьяалал, элсэлтийн асуудал	8 дугаар сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс
9	“Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилт	8 дугаар сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн

			ХЭЛТЭС
10	“Боловсрол-2016 хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс
11	“Цахим сургууль, цахим цэцэрлэг хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс
12	“Цахим эрүүл мэнд хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
13	“Халамжаас хамгаалалд, хамгааллаас хөдөлмөрт хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
14	“Хамтдаа хөгжвө хөтөлбөр”-ийн хэрэгжилт	10 дугаар сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс
15	“Хотын иргэн, хотын соёл хөтөлбөр”-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
16	“Манлайлан суралцагч оюутан, сурагчдыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтэс
17	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийн явц, байдал /харьяалах асуудлаар/	12 дугаар сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газар
18	Хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын Ажлын алба
ГУРАВ. ИРГЭНИЙ ОРОЛЦОО, САНАЛ ХҮСЭЛТИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО			
1	Иргэний танхимын үйл ажиллагаа, иргэний оролцоог хангах чиглэлээр зохион байгуулж буй ажил, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	6, 12 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс
2	“Иргэний оролцоог дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт	9 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс

3	Иргэдийн бүлэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажил	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс
4	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол түүний шийдвэрлэлтийн байдал	11 дүгээр сард	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
5	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийн явц, байдал /харьяалах асуудлаар/	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газар
6	Хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын алба
ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, ТОХИЖИЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО			
1	Гэр хорооллын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, дахин төлөвлөлт, нэг өрх-нэг сууц төслийн үйл ажиллагаатай танилцах	5 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
2	Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих БИТ, Дүүргийн хөгжлийн инновацын төв, "Чингэлтэйд үйлдвэрлэв цэг"-ийн үйл ажиллагаа	6 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний хэлтэс
3	Миний гудамж, Гэрэлтэй гудамж төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	6 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
4	Авто зам, явган замын засварын ажил, гэрэлтүүлэг, цахилгаан эрчим хүч, хаяржилтын ажил	8 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
5	Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хороодын өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтийн хэлтэс
6	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	10 дугаар сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс
7	Хоршоо хөгжүүлэх дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	10 дугаар сард	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөрийн хэлтэс
9	"Ахуй үйлчилгээг дэмжих дүүргийн дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилт	11 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Худалдаа үйлчилгээний хэлтэс
8	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийн явц, байдал /харьяалах асуудлаар/	12 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
10	Хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын алба

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОЛОГИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

1	Гамшиг, аюул ослын байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, үзүүлэх сургалт	4 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын хэлтэс
2	Ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа	6 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтийн хэлтэс
3	Чингэлтэй хайрханы ойжуулалт, булаг шандны хамгаалалт	6 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтийн хэлтэс
4	Зуслангийн ногоон бүс, зуслангийн товчоо, эко эрлүүгийн үйл ажиллагаа	7 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтийн хэлтэс
5	Хашаа, явган зам, гудамж арга хэмжээний явц, хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын дэргэдэх Өмч, газрын харилцааны алба
6	Ногоон дүүрэг хөтөлбөрийн хэрэгжилт	9 дүгээр сард	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилтийн хэлтэс
7	Дүүргийн газар зохион байгуулалтын 2015 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2016 оны төлөвлөгөөний төсөл	12 дугаар сард	Засаг даргын дэргэдэх Өмч, газрын харилцааны алба
8	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийн явц, байдал /харьяалах асуудлаар/	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газар
9	Хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын алба
ЗУРГАА. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮГИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО			
1	Дүүргийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай	2 улирал	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс
2	Дүүргийн 2016 оны төсвийн төсөл	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс
3	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилтын хэрэгжилтийн явц, байдал	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газар
4	Хурлын хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын Ажлын алба
ДОЛОО. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО			

1	Нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр 2015 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний мэдээлэл	10 дугаар сард	Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс
2	Дүүргийн 2014 оны төсвийн гүйцэтгэл	2 улирал	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс
3	Дүүргийн Нийгэм, эдийн засгийн 2015 оны зорилгын хэрэгжилтийн явц, байдал	12 дугаар сард	Засаг даргын Тамгын газар
4	Хурлын хорооны нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын алба

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 сарын 21-ний
өдрийн 02 дугаар тогтоолын гурвдугаар хавсралт



ЧИЭНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНААС
2015 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага
НЭГ. ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР				
1	Хурлын Төлөөлөгчид, ажлын албаны ажилтнууд, дүүргийн болон Хороодын Засаг дарга нарын хөрөнгө орлогын мэдүүлэг хүлээн авах, холбогдох газарт тайлагнах	2 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Авлигатай тэмцэх газар
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилах, энэ чиглэлийн ном гарын авлага, үзүүлэн материал бэлтгэн тараах	2 сар	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Авлигатай тэмцэх газар
3	Хурлын видео танилцуулга бэлтгэх /Монгол, Англи хэл дээр/	3 сар	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Мэргэжлийн байгууллага
4	Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого зохион байгуулах	6, 12 сар	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	-
5	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах	Хуваарийн дагуу	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтэс
6	Төлөөлөгчдийн тойрогтоо ажилласан байдал, оролцоо, үйл	Улирал	Хурлын ажлын албаны	Хорооны Иргэдийн

	ажиллагааны тайланг Төлөөлөгч тус бүрээс гаргуулан авч, үйл ажиллагааг нь иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	бүр	Зохион байгуулалтын хэлтэс	Нийтийн Хурал, Засаг даргын Ажлын алба
7	Шашны байгууллагын үйл ажиллагаанд гаж урсгал, буруу зан үйлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтын ажил зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Дүүргийн ГХУСАЗЗ
8	Хурлын байгууллагын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, вэб сайтат байршуулан, тогтмол баяжилт хийж ажиллах	Жилийн турш	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
9	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэний танхим, иргэний оролцоо хөгжсөн гадаад улс орнуудын ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах; харилцан туршлага солилцох арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
10	Гадаад томилолт, арга хэмжээнд Хурлын Төлөөлөгч, Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албад, хороодын ИНХ, Засаг даргын ажлын албаны албан хаагчдыг хамтын ажиллагааны чиглэл, ач холбогдлынх нь хүрээнд хамруулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
11	Хурлын хороодоос 2015 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	Жилийн турш	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
12	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Жилийн турш	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
13	Хурал, Тэргүүлэгчдээс 2015 онд хэлэлцэх асуудлын сэдэвчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Хуваарийн дагуу	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
14	Амар тайван Чингэлтэй хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Жилийн турш	Дүүргийн ГХУСАЗЗ	Засаг даргын Тамгын газар

15	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах дүүргийн салбар комиссын 2015 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	Жилийн турш	Дүүргийн ЦАУЗБСКомисс	Засаг даргын Тамгын газар
16	Дүүргийн Улаан загалмайн хорооны 2015 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	Жилийн турш	Дүүргийн УЗХороо	Засаг даргын Тамгын газар

ХОЁР. ТӨВЛӨРСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

1	Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	1 дүгээр сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газар
2	Иргэдийн үүсгэл санаачлагын бүлгийн үйл ажиллагааг дэмжиж чадавхжуулах сургалт зохион байгуулах	2 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Худалдан авах ажиллагааны алба
3	Эх орончдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	3 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газар
4	Олон Улсын эмэгтэйчүүдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	3 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газар
5	“Хангарьд” спорт өдөрлөг зохион байгуулах	4 дүгээр сард	Хурлын ажлын алба	Нийслэл, дүүргүүдийн ИТХ
6	Эрүүл мэндийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулах	4 дүгээр сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Цэргийн штаб, хороодын Өрхийн эрүүл мэндийн төв
7	Дүүргийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх “Сайн үйлсийн аян”-ыг зохион байгуулах	5 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газар
8	Хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулах	6, 10 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Мэргэжлийн байгууллага

9	“Авлига би авахгүй, өгөхгүй” сургалт зохион байгуулах	6 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Авлигатай тэмцэх газар
10	Дүүргийн иргэний танхимын дэргэдэх залуучуудын клубуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, шилдэг залуу идэвхтэн, клубыг шалгаруулах	8 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс
11	Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах	9 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Монголын нутгийн удирдлагын холбоо
12	Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэнийг шалгаруулах ажлыг зохион байгуулах	10 дугаар сард	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Ахмадын хороо
13	Ахмадын чуулга уулзалт зохион байгуулах	10 дугаар сард	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газар
14	Шилдэг Аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах арга хэмжээ зохион байгуулах	12 дугаар сар	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар
15	Хурлын Төлөөлөгчдийн иртэд, сонгогчидтой хийх уулзалт, арга хэмжээ зохион байгуулах	Улирал тутамд	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газар Хороодын ИНХ, Засаг даргын Ажлын алба
16	Хурлын байгууллагын үйл ажиллагааг чадавхжуулах, Төлөөлөгчдөд мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах	Улирал тутамд	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Мэргэжлийн байгууллага
17	Хурлын хороодын нэрэмжит өдөрлөг зохион байгуулах	Тухай бүр	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар Харьяа хэлтэс

				албад
18	“Төлөөлөгчийн нэг өдөр өдөрлөг”-ийг зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс	Засаг даргын Тамгын газар Харьяа хэлтэс албад
ГУРАВ. БАЙГУУЛЛАГА, ИРГЭДТЭЙ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
1	Хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмын хэрэгжилт, Улсын Их Хурал, Засгийнгазар, дээд шатны болон өөрийн Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг иргэд олон нийтэд сурталчилгах	Сар тутам	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Хороодын Иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын ажлын алба
2	2016 оны Орон нутгийн хөгжлийн санд иргэдээс авах санал асуулга хороодын айл өрхөөр орсон эсэхэд түүврийн судалгааны аргаар хяналт тавих	3 дугаар сар	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг төлөвлөлтийн хэлтэс
3	Хороодын Засаг дарга, өрхийн эрүүл мэндийн төв, хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх Иргэдийн Нийтийн Хурал зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, үр дүнг нь тооцон ажиллах	1 дүгээр улирал	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс
4	Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын талаар иргэдээс авсан саналыг эрэмбэлэх хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	4 дүгээр сар	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Хороодын Иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын ажлын алба
5	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2015 оны нийгэм эдийн засгийн зорилтын хэрэгжилт, явц байдлыг иргэдэд сурталчилгах	Улирал тутам	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс	Засаг даргын Тамгын газрын Эдийн засаг

			төлөвлөлтийн хэлтэс
6	Иргэдийн сайн дурын бүлэг, бүтээлч санал санаачлагыг дэмжин тэдний хийсэн ажлыг олон нийтэд сурталчилах	Жилдээ	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс
7	Сайн дурын хүмүүнлэгийн байгууллагуудын оролцоотойгоор олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх	Жилдээ	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс Дүүргийн Улаан загалмайн хороо
8	Төрийн цол, одон медалиар шагнагдсан хүмүүст хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
9	Хурлын шагналаар шагнагдсан хүмүүст хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Хурлын ажлын албаны Зохион байгуулалтын хэлтэс Засаг даргын Тамгын газрын Захиргаа хуулийн хэлтэс
10	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч судлан шийдвэрлүүлэх, хэрэгжилт, явц байдлыг иргэдэд шуурхай мэдэгдэх, энэ чиглэлийн мэдээ тайланг гаргах	Тухай бүр	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс
11	Хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэрийн төсөл, Хороонд тулгамдаж байгаа асуудлаар иргэдээс санал авах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагад уламжлах	Тухай бүр	Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс Засаг даргын Тамгын газрын Захиргаа, хуулийн хэлтэс

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**“Амар тайван Чингэлтэй”
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Амар тайван Чингэлтэй” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /С.Туяа/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100 05



“Амар тайван Чингэлтэй” хөтөлбөр (2015-2016)

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөр”, “Хүн худалдах ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах хөтөлбөр”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр”, “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, Гэмт хэргийн гаралтыг бууруулах урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан иргэдийн аюулгүй амьдрах бололцоог бүрдүүлэхэд төрийн болон хууль хяналтын байгууллагууд ажлын уялдаа холбоог сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж цаашид хамтарч ажиллах шаардлага урган гарч байгаа нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүх нийтийн үйл хэрэг болгож, төр олон түмний хүчин чармайлтыг нэгтгэсэн үйл ажиллагааг түүнд чиглүүлэх нь хөрөнгө, хүч, цаг хугацаа хэмнэх ач холбогдолтой. Үүний тулд гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн ажлын үр дүнг үнэлэх механизмыг боловсронгуй болгох урьдчилан сэргийлэх ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх цаг үеийн шаардлага бий болоод байна.

Хууль, эрх зүйн талаархи мэдлэг, мэдээлэл дутмагаас болж иргэд гэмт хэргийн золиос болох нь түгээмэл бөгөөд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилтыг хангахад гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, тайлбарлан таниулах, энэ талаар сургалт зохион байгуулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг тэдэнд эзэмшүүлэх явдал чухал ач холбогдолтой юм.

Мөн түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллага, гэр бүл, иргэний оролцоо чухал үүрэгтэй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тэдгээрийн оролцоонд түшиглэн тогтмол явуулах нь зүйтэй юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, энэ чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагаанд талуудын оролцоог нэмэгдүүлж, үр дүнтэй зохион байгуулахад оршино.

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг иргэдэд эзэмшүүлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Үйл ажиллагааны бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан үндэсний хууль тогтоомж, бодлого, стратеги, бусад олон

улсын болон үндэсний хэмжээний хүний эрх, хөгжлийн талаар тавьж буй зорилтыг хангахад чиглэгдсэн болно.

Гурав. Хөтөлбөрийн зорилт:

- Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчинг бүрдүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг нэгдсэн бодлоготойгоор явуулах, энэ ажилд иргэд, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх
- Иргэдийн эрх зүйн ухамсарыг төлөвшүүлж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх.
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэний оролцоог нэмэгдүүлэх, санал санаачлагыг дэмжих
- "Архи, Тамхигүй Чингэлтэй" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн архи, тамхины хэрэглээг багасгах, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх.
- Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах талаар хамтран нэгдсэн ажил, арга хэмжээ зохион байгуулах.
- Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийг судлан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, хөдөлгөөний соёл, хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах.
- Шинэ төрлийн гэмт хэрэг буюу Галт зэвсэг, хар тамхи мансууруулах бодисын хууль бус наймаа, мөнгө угаах, оюуны өмчийн хулгай, кибер болон эко терроризм, хүний наймаа, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох.
- Гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, гамшгийн тоог бууруулахад чиглэсэн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхжүүлсэн, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг явуулах
- Хүүхэд, залуучуудыг оролцоог тэгш нэмэгдүүлж, таатай орчинг бүрдүүлэх
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон хувилбараар, нээлттэй байх зарчмыг баримтлан зохион байгуулна.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт:

- "Амар тайван Чингэлтэй" хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хянаж, үнэлэх үүргийг Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хүлээнэ.
- "Амар тайван Чингэлтэй" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, холбогдох журам, шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтыг дүүргийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, жил бүрийн төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангах

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

1. Соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах зорилтын хүрээнд:

- Хүүхдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, хүүхэд хамгааллын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна.

- Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг хүүхдийн сэтгэхүйд тохирсон шинэлэг хэлбэрээр зохион байгуулах;
- Өсвөр үе, залуучуудыг эх оронч үзэл хандлагыг ухамсарлуулах, гэмт хэрэгт өртөх, мансууруулах бодис, түүний хор уршигийг сурталчилан таниулах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, зөв соёлч иргэн болгох нөлөөллийн үйл ажиллагааг Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран хийх
- Ял хойшилсон хүүхдүүдийг нийгэмшүүлэх, төлөвшүүлэх, амьдрах ухааны цуврал үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- Гэмт хэргийн хохирогч гэрч хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдний асуудлаар шүүх хуралд төлөөлөн оролцох тэдэнтэй ажиллах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх

Хүрэх үр дүн:

1. Шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлж, санал санаачилгыг дэмжин, шийдвэр гаргагчдад нөлөөллийн ажил зохион байгуулна .
 2. Хүүхдийг аливаа эрсдэл, хорт зуршил, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдэд олгоно.
 3. Сургууль, цэцэрлэгийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, хурд сааруулагч байрлуулж, замын тэмдэг тэмдэглэгээ тавина.
 4. Сургалт, хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг дүүргийн хэмжээнд улирал тутам 100 орчим залуусын төлөөллийг хамруулж, хөтөлбөр боловсруулж, хороодод хүргүүлж Иргэний танхимаар дамжуулан зохион байгуулна.
 5. Өсвөр үе залуучуудад болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудыг дүүргийн Цагдаагийн хэлтсүүд болон Төрийн бус байгууллагатай хамтран улирал тутам 200 орчим өсвөр үе залуучуудын төлөөллийг хамруулан зохион байгуулагдсан байна. Хороо бүрт өсвөр үе, залуучуудыг эх оронч үзэл хандлагыг ухамсарлуулах, гэмт хэрэгт өртөх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, зөв соёлч иргэн болгох нөлөөллийн ажил улирал бүр хийгдсэн байна. Жил нэг удаа компанит ажил зохион байгуулагдсан байна.
2. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг арга хэмжээний зорилтын хүрээнд:
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор иргэдийн хандлагыг өөрчлөх сургалт сурталчилгааг төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион явуулах
 - Гэмт хэрэгт холбогдож болзошгүй, насанд хүрээгүй хүүхдүүдийн судалгааг гаргаж, Хүүхэд оролцооны танхимыг түшиглэн тэднийг хөгжүүлэх олон талт сургалт, гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх зөв боловсон амьдрах мэдлэг олгох сургалт зохион байгуулах
 - Хүүхдийн хууль зүйн хороогоор дамжуулан Хүүхдийг хууль зөрчих үйлдлээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах
 - Гэр бүлийн хүчирхийллийн талаархи иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулах

Хүрэх үр дүн:

1. Гэр бүлийн хүрээнд үйлдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах
 2. Хүүхэд оролцооны танхимыг түшиглэн тэднийг хөгжүүлэх олон талт сургалт, гэмт хэрэгт холбогдохоос сэргийлэх, зөв боловсон амьдрах мэдлэг олгоно
3. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд:
- Архины хамааралтай иргэдийн зан үйлийг төлөвшүүлэх, архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах, Төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж үр дүнг тооцон ажиллах
 - Согтууруулах ундаа болон тамхи худалдан борлуулдаг үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд нэгдсэн үзлэг шалгалтыг зохин байгуулж, тавих хяналтыг сайжруулах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний хэрэглээг бууруулах сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, хэрэглээний соёлыг төлөвшүүлэх

Хүрэх үр дүн:

1. Архи, тамхинаас татгалзах хамт олны тоо нэмэгдэх
 2. Согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын цагийн хуваарьт хяналт шалгалтыг тогтмол хийж, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн тоо буурах
4. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:
- Хорих ял эдлээд суллагдсан, тэнсэн суллагдсан ялтнуудыг нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх, тэднийг ажилд зуучлах, ажлын байраар хангах өдөрлөг зохион байгуулах
 - Тэнэмэл гэгдэх иргэдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд тэднийг бүртгэлжүүлж, судалгаанд хамруулах, тэдний дунд “Шинэ өдөр” өдөрлөгийг тогтмол хэрэгжүүлж, өдөрлөгийн хүрээнд тэнэмэл иргэдийг усанд оруулах, хооллох, тэднийг нийгэмшүүлэх чиглэлийн олон талт сургалт зохион байгуулах
 - Авилгатай тэмцэх, нийтийн болон ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах
 - Хороодын салбар зөвлөлийн үйл ажиллагаа, иргэд, Төрийн болон Төрийн бус байгууллагуудын идэвхи, санаачлагыг идэвхижүүлэх зорилгоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоо - 2015, 2016, 2017” төслийн уралдаан зарлаж, шалгарсан төслийг сурталчилах, санхүүжүүлэх
 - Хороодын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд туслах чиг үүрэг бүхий хэв журмын урамшилтай эргүүлүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг улирал бүр зохион байгуулах
 - Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, тэдгээрийн санал, санаачлагыг дэмжин ажиллах, байгаль орчныг хамгаалах иргэдийн сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагааг сурталчлах, тэдний үйл ажиллагааг дэмжин урамшуулах
 - Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, сахилга хариуцлагыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх
 - Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ерөнхий болосролын сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж байгууллагуудад галын хорыг хэрхэн хэрэглэх, осол аваарт орсон тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны

тусламжийг хэрхэн үзүүлэх талаар мэдлэг олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах

Хүрэх үр дүн:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахиулах эргүүл, хяналтын ажилд иргэд, олон нийтийн оролцоог ханган, гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, илрүүлэлтийн түвшинг дээшлүүнэ.
2. Иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хэрхэн бүрдүүлж буй талаарх санал асуулга авах, иргэдийн санал хүсэлтийг сонсож, шуурхай шийдвэрлэх,
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, гэр бүлийн оролцоо нэмэгдэх
4. Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг эзэмшинэ.

5. Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:

- Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүнсний тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн арга хэмжээ, сургалт сурталчилгаа зохион байгуулах
- Аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийг тогтмол явуулж, ажлын байрны нөхцөлийг сайжруулахад оршин суугчдын саналыг авч, зөвлөмж, арга зүйгээр хангах
- Дүүргийн хэмжээнд бүх үйлчилгээний газруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэгдсэн анхааруулах санамж бүхий зөвлөмж гаргаж ажиллах

Хүрэх үр дүн:

1. Холбогдох стандартын дагуу зөвлөмж боловсруулах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, сургалт, үзүүлэх сургалтыг зохион байгуулна.
2. Холбогдох хууль тогтоомжийг сахин биелүүлж байгаа худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг урамшуулж, хэвлэл мэдээллээр сурталчилж ажиллана

6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:

- Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинээр гарч байгаа хууль тогтоомжийг сурталчлах, тайлбарлан таниулах, аливаа гэмт халдлага, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, чадварыг иргэдэд эзэмшүүлэх замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх
- Хэвлэл мэдээллийн байгууллага, электрон дэлгэц ашиглан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар мэдээлэл гаргах, санамж, уриалга гарган сурталчилах ажлыг зохион байгуулах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг үр өгөөжтэй, ойлгомжтой хэлбэрээр иргэдийн нас, хүйс, сонирхол, онцлогт тохируулан явуулах

Хүрэх үр дүн:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны хүртээмж, чанар сайжирч, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилэх

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, олон нийтэд хүргэх тогтолцоо бүрдэнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог нэмэгдэнэ.
- Залуучуудын талаар хийгдэж буй ажлын үр дүнг хянаж үнэлэх, тулгамдсан асуудлыг шийдэх арга хэмжээ цогцоор шийдэгдэх нөхцөл бүрдэнэ
- Төр захиргааны болон хууль хяналтын байгууллагууд, хороодын салбар зөвлөлтэй хамтран урьдчилан сэргийлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах нөхцөл бүрдэнэ
- Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, хариуцлагыг өндөржүүлж, тэдний санал санаачлагыг дэмжих, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулж, тэд нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, оролцоо жигд хангагдана.

Найм. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хугацаа, санхүүжилт

- Дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хамруулна.
- Хөтөлбөрийг 2015-2016 онд хэрэгжүүлнэ.
- Дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:
 - Орон нутгийн төсөв, нийслэл, улсын төсөв
 - Гадаад, дотоодын төсөл хөтөлбөр
 - Аж ахуй нэгж байгууллагын хандив



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төлбөр гаргуулж, “Гоулдрич ХХК”-д олгох тухай шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

2. “Гоулдрич ХХК”-д олгох төлбөр 22450000 (хорин хоёр сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



1150100 08